“БОДЬТУСГАЛ-АУДИТ” ХХК ‘BODITUSGAL-AUDIT’ LLC

Хараат бус аудитын байгууллага

Улаанбаатар хот
Баянгол дүүрэг 1дүгээр хороо
“Газар бизнес төв” 316 тоот
Утас: 11305165, 99080074
И-мэйл:boditusgal.audit@gmail.com

2024 оны 3 сарын 28 өдөр

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“НАНДИНЗООС КРЕДИТ ББСБ” ХХК-ийн УДИРДЛАГАД

Бид танай байгууллагын 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бусад нэмэлт тайлбар тодруулгыг баггаасан санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Зөрчилгүй дүгнэлт
“Нандинзоос кредит ББСБ” ХХК нь 2023 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайлангаа холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл
Бид энэхүү аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэв.
Уг стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн “Аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага” хэсэгт харуулсан болно. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагын дагуу танай байгууллагаас хараат бусаар ажиллах үүргээ бүрэн биелүүлсэн билээ.
Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд
Бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй зүйлсийг аудитын гол асуудлууд гэж үзнэ. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл
Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хамраагүй тул түүнд баталгаажуулалт гаргахгүй.

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг
Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын холбогдох олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь байгууллагын удирдлагын хүлээх үүрэг юм. Энэхүү үүрэгт залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлан бэлтгэх, толилуулах үүрэг бүхий дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх ажлууд багтана. Удирдлага санхүүгийн тайланг гаргахдаа байгууллагын үйл ажиллагааг цаашид тасралтгүй явуулах үүрэг хариуцлага хүлээсэн байна.

Аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага
Хийсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх нь бидний үүрэг хариуцлага юм.
Бид танай байгууллагын санхүүгийн тайланг материаллаг алдаагүй бэлтгэгдсэн тухай найдвартай, хангалттай нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, түүнийг Аудитын олон улсын стандарт болон Аудитын дотоод стандартыг баримтлан хийв.
Аудит хийхдээ аудитын горим (Шалгах, давтан тооцоолох, тулган баталгаажуулах, тасалбар болголт, тулгах гэх мэт)-уудыг ашиглав.
Байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан бөгөөд цаашид ч уг зарчмыг баримтлах юм байна.

Тайлангийн зориулалт
Энэхүү тайланг “Нандинзоос кредит ББСБ” ХХК-ийн хувь нийлүүлэгчдэд зориулан бэлтгэв. Бид энэ тайлангийн агуулгын хүрээнд гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Аудиталсан санхүүгийн тайлангийн тодруулгыг хавсаргав.

УЛААНБААТАР ХОТ
БОДЬТУСГАЛ-АУДИТ
ЗАХИРАЛ
ТТ33401 ☎ 5489903

З.МЯГМАРСҮРЭН

НАНДИН ЗООС КРЕДИТ
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

(мян.төг)

ҮЛДЭГДЭЛИЙН ТЭНЦЭЛ	2023.12.31 Тайлант үеийн дүн
Мөнгөн хөрөнгө	196.1
Зээл	1,764,215.0
ЗЭСан	-120,803.5
Бусад актив	998,378.2
Үндсэн хөрөнгө	350,140.3
Хуримтлагдсан элэгдэл	-48,707.5
Биет бус хөрөнгө	1,283.3
НИЙТ ХӨРӨНГӨ	**2,944,702.1**
Богино хугацаат өглөг	485,151.0
Бусад өглөг	16,961.8
Ердийн хувьцаа	2,220,000.0
Тайлант үеийн ашиг	138,164.7
Хуримтлагдсан ашиг	84,424.5
НИЙТ ЭХ ҮҮСВЭР	**2,944,702.1**

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН	
Хүүний орлого	390,727.7
Хүүний зардал	-96,051.6
Цэвэр хүүний орлого	**294,676.1**
Хүүний бус орлого	0
Хүүний бус зардал	-120,652.8
Зээлийн эрсдлийн зардал	-24,493.1
Үйл ажиллагааны ашиг	**149,530.1**
Үйл ажиллагааны бус орлого	9,989.5
Үйл ажиллагааны бус зардал	-6,003.2
Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	**153,516.4**
Орлогын татварын зардал	-15,351.7
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/	**138,164.7**